ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 01 дүгээр сарын 30 өдөр Дугаар 07 Хэрлэн сум

Аймгийн Онцгой комиссын VII хуралдааныг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 09:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 27 гишүүд оролцохоос 26 гишүүнтэй 96% ирцтэй хуралдав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ний удирдлагуудаас Дорнод аймгийн удирдлагуудтай уулзалт хийх саналын дагуу тээвэрлэлт хийлгэх талаар санал солилцсон тухай танилцуулах;
2. Онцгой байдлын газрын жижүүрийн утсанд 21 дүгээр талбайгаас газрын тос тээвэрлэдэг жолооч, Иргэн Э-гийн мэдээллэсний дагуу шийдвэр гаргах;

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монгол Улсын Засгийн газрын хамтран ажиллах гэрээ, иргэний хуулийн дагуу зөрчилдөж байгаа тул "Петрочайна Дачин Тамсаг" ХХК Улсын Онцгой комиссд хүргүүлсэн албан бичгийн хариу, Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын мэдээлэл, Улсын Онцгой комиссын 2020 оны 01 дүгээр сарын 30-ны 14:00 цагийн хурлын шийдвэрийг үндэслэх;

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяад:

1. Дорнод аймгийн худалдааны төв, дэлгүүрүүдэд эрүүл ахуйн хяналтыг зөвлөн туслах чиглэлээр зохион байгуулж дүн мэдээг Онцгой комиссын даргад танилцуулахыг;

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаад:

1. Дорнод аймгийн хэмжээнд 2019 онд томуу, томуу төст өвчний өвчлөлийн мэдээллийг аймгийн Онцгой комиссын 08 дугаар хуралдаанд танилцуулахыг;

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ, ОНЦГОЙ КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА Ч.ГАНБАТ

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, ДЭД ХУРАНДАА Д.БАТТУЛГА